



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/343

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумд ойрын өдрүүдэд орж буй усархаг борооны аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ажлын хэсгийг нэгдүгээр, борооны улмаас учирсан хохирлыг үнэлэх, барагдуулах ажил зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар, гамшгийн хохирлыг барагдуулах техникийн бэлэн байдлыг хангаж ажиллуулах ажлын хэсгийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гамшгийн хохирлыг багасгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд аймагт ажиллаж буй цэргийн хүрээ, анги салбарын болон иргэд, аж ахуйн нэгжийн техник хэрэгсэл холбогдох мэргэжлийн анги салбарын ажилтан албан хаагчдыг хохирол барагдуулах, гамшгийг бууруулах хүртэл хугацаанд зохих хуулийн хүрээнд дайчлан ажиллуулсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнаж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

06 Аймгийн Засаг даргын 2025 оны
.....дугаар сарын 17-ны өдрийн 114 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Алтангэрэл (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Б.Дорждэрэм (Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч) (хурандаа)
Д.Төмөрбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга) (хурандаа)
Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын дарга) (хурандаа)
Э.Пүрэвжав (Есөнбулаг сумын Засаг даргын орлогч)
Б.Болд-Эрдэнэ ("Бумбат даваа" ХХК-ийн захирал)
Нарийн бичгийн дарга: Б.Бямбадорж (Аймгийн ерөнхий архитектор)

__ оОо __

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 17 ны өдрийн 169 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Л.Хаш-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд: Л.Ганхуяг (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Ж.Батцэцэг (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Ч.Батзориг (Улаан загалмайн хорооны дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Цээндэр (Онцгой байдлын газрын ахлах нягтлан бодогч)

__ оОо __

Аймгийн Засаг даргын 2025 оны 06
дугаар сарын 17-ны өдрийн 1743 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

ДАЙЧИЛГААНЫ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Н.Мэндбаяр	(Аймгийн Цагдаагийн газрын дарга) (цагдаагийн хурандаа)
Гишүүд:	Д.Чинзориг	(Аймгийн Засаг даргын Тамгын Газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Н.Алтанбагана	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Н.Золжаргал	(Есөнбулаг сумын Засаг дарга бөгөөд Алтай хотын захирагч)
	С.Гантулга	(Аймгийн Автотээврийн төвийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Б.Батдорж	(Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч)